ХУРГАТАЙ ХАЙРХАН

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АХЛАХ АНГИЙН СУРАГЧДАД ЗОРИУЛСАН 2025 ОНЫ ЗУНЫ СУРГАЛТ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



ХУРГАТАЙ ХАЙРХАН



Сургалтыг “Хөвсгөл Олон Улсын Хүүхдийн Зуслан”-тай хамтран 2025 оны 7-р сарын 23-наас 8-р сарын 7-ны хооронд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг буюу Хөвсгөл нуурын зүүн эрэг дээр зохион байгуулсан ба сургалтад **Цэцэрлэг болон Цагаан-Уул сумын ахлах ангийн 10 сурагч** хамрагдлаа.

Цагаан-Уул сумын ЕБС-ийн 11в ангийн сурагч Б.Ирмүүн

Зуны сургалтанд явснаар миний англи хэл, математик маш их сайжирсан. Мөн мэргэжил сонголт дээр олон зүйл сурлаа.

ХУРГАТАЙ ХАЙРХАН

“Хургатай Хайрхан” ХХК нь сурагчдын **сургалтын төлбөрийг бүрэн даан**, хойд бүсийн хүүхдүүдийг олон улсын түвшний сургалтад оролцох боломжоор хангалаа.





ХУРГАТАЙ
ХАЙРХАН



Хөтөлбөрийн хүрээнд сурагчид
нийт 70 цагийн сургалтад
хамрагдсан бөгөөд англи хэл,
математикийн гүнзгийрүүлсэн
хичээл болон мэргэжил сонголтын
зөвлөгөө авсан юм.

Сургалтын хамгийн дурсамжтай үе нь үеийнхээ хүүхдүүдтэйгээ Хөвсгөл нуурын эрэг дээрээс байгалийг ямар гайхамшигтай үзэсгэлэнтэй вэ гэдгийг харсан.



Цагаан-Уул сумын ЕБС-ийн 11б ангийн сурагч Н.Амарсанаа

ХУРГАТАЙ ХАЙРХАН





Сургалтын дараа сурагчдын мэдлэг, чадварын түвшин мэдэгдэхүйц ахиж, зарим нь **30 хувийн үзүүлэлтээс 95 хувьд хүрсэн нь** энэ хөтөлбөрийн бодит үр дүнг илтгэн харууллаа.

Бид орон нутгийн хүүхдүүдийн боловсролд хувь нэмэр оруулахын зэрэгцээ тэдний ирээдүйд хөрөнгө оруулан ажиллаж байна.



ХУРГАТАЙ ХАЙРХАН





Бидний энэхүү санаачилга цаашид жилээс жилд улам өргөжинө гэдэгт итгэлтэй байна.





Зураг. Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сум 2024 он
“Хургатай Хайрхан” ХХК-ийн хэрэгжүүлдэг “Малын ногоон тэжээл” хөтөлбөрийн тариалангийн талбай

ХУРГАТАЙ
ХАЙРХАН

Байгальд ээлтэй
Орон нутагт өгөөжтэй